

Хүчирхэг илтгэл High Impact Presentations



Хэн оролцох вэ?

Байгууллагаа төлөөлөн олон нийттэй харилцдаг ажилтнууд, хүний нөөц, ахлах, супервайзор, менежер, удирдлагууд

Хөтөлбөрийн зорилтууд:

- Илүү үр дүнтэй харилцаа, хувь хүний болон мэргэжлийн имижид гарах өөрчлөлтийг харах
- Өндөр үр дүнтэй харилцагч болохоор өөртөө зорилт тавих
- Байгууллагынхаа эерэг имижийг илтгэх
- Нэмэлт баримт нотолгоогоор өгөх гэж зорьж буй мессежээ улам бэхжүүлэх
- Үр дүнтэй асуулт хариултын цагийг зохион байгуулах
- Төвөгтэй асуудлыг энгийн ойлгомжтой болгоход уян хатан ажиллах
- Санаа бодлоо илүү логиктойгоор илэрхийлэх
- Өөрийн харилцаанд илэрхийлэл, хурд/зогсолт, биеийн хэлэмж, дууны өнгийг ашиглах замаар илүү амьджуулж, тодорхой болгох
- Уян хатан байдлыг хязгаарлаж буй саад тотгорыг даван туулах
- Үзэгчдийг аливаа алхмыг хийхэд уриалах
- Бодит, нотолгоотой баримттай түүх ярих
- Урам зоригтой, ил тод байх
- Ятгах хэлбэрээр харилцах
- Дарамт шахалтан доор ажил хэрэгч байдлаа алдахгүй байх
- Эерэг, ил тод мессежтэй харилцах
- Стратегийн ач холбогдол бүхий санаа, хүн, байгууллагыг борлуулах
- Стресстэй нөхцөл байдлыг удирдахад манлайлах чадвараар харилцах
- Үзэгчдийн сэтгэл хөдлөл, логикт хүрэх
- Үзэгчдийн итгэлийг олж авахад бүтцийг ашиглах

Илтгэлийн хөтөлбөр нь 2 трэйнэр багштай явагдана. Сургалтын турш видео бичлэгтэй явагдах бөгөөд ганцаарчилсан көүчинг хийгдэнэ.

Сургалт 2 танхимд явагдах ба үндсэн танхимд сургалт явагдана, хажуугийн туслах танхимд ганцаарчилсан көүчинг хийгдэнэ.

Энэ хөтөлбөрийг байгууллага дээрээ зохион байгуулах эсвэл цөөн хүнийг манайхаас олон нийтэд зарлагдаж буй сургалтад хамруулах боломжтой.

№	Модуль	Суралцах зүйлс
1	Анхны эерэг сэтгэгдэл төрүүлэх	• Эерэг анхны сэтгэгдэл төрүүлэх • Илтгэгчийн хувийн жишиг бий болгох • Сургалтаар хүрэх хувийн зорилтуудаа тодорхойлох • Үзэгч, сонсогчидтой нөхөрсөг харилцаагаа сайжруулах
2	Итгэл төрүүлэх чадвараа сайжруулах	• Итгэл төрүүлэх байдлаа давуу ашиглан харилцах • Байгууллагын эерэг талыг илтгэх • Хүсэл тэмүүллийг хүргэх • Өөртөө итгэлтэйгээр чадвараа харуулах • Нотолгоогоор мэдээллийн гол санааг бэхжүүлэх

3	Цогц мэдээллийг тодорхой илтгэх	• Цогц мэдээллийг энгийн ойлгомжтойгоор хүргэх чадвараа хөгжүүлэх • Мэдээллээ сонирхолтойгоор хүргэх • Сонсогчдынхоо ижил түвшинд харилцаа тогтоох • Санаа бодлоо логик дараалалтайгаар дагах • Сэтгэл хөдлөлтэйгөөр холбогдох чадвараа хөгжүүлэх
4	Хүчирхэг нөлөөлөлтэйгөөр харилцах	• Илэрхийлэл, дохио зангаа болон дуу хоолойг ашиглаж уян хатан байдлаа хөгжүүлэх • Сайн мэдэхгүй агуулгад эзэн болж, өөртөө итгэлтэйгээр илтгэх • Бичгэн мэдээллийг анхаарал татахуйцаар илтгэх • Уян хатан байдалд саад бологч хүчин зүйлсийг давж гарах
5	Бусдыг идэвхижүүлж үйлдэлд уриалах	• Үр дүнд чиглэсэн байдлаар илтгэх • Сонсогчдыг үйлдэлд ятгах • Өөрийн түүхээр итгэл, үнэмшилтэй нотолгоо санал болгох • Товч, тодорхой ба урам зориг өгөхүйц байх • Үнэмшил төрүүлэхүйцээр харилцах
6	Хүнд хэцүү нөхцөл байдлыг даван гарах	• Хүнд нөхцөл байдалд мэргэжлийн байдлаа хадгалах • Эерэг санааг товч, тодорхой илэрхийлэх • Өөрийн болон байгууллагын санал, санаачилгыг хүлээн зөвшөөрүүлэх • Өөртөө итгэлтэйгээр, чадварлаг харилцах • Стресстэй байдлыг шийдвэрлэхдээ манлайллын чадвараа ашиглах
7	Өөрчлөлтийг нээлттэй хүлээн авах, урам өгөх	• Сонсогчдын сэтгэлийг хөдөлгөж, логиктойгоор уриалах • Илтгэлийн бүтэц ашиглан сонсогчдын итгэлийг олох • Сонсогчдыг үйлдэлд хөтлөхдөө итгэл үнэмшилтэй байх • Санал болгож буй санаагаа дэмжих нотолгоо өг • Зөрж буй санаагаа тулгалгүйгээр дэвшүүл